



ДУНДГОВЬ АЙМАГ
ГОВЬ-УГТААЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 02 сарын 08 өдөр

Дугаар 01/15

Хажуу шинэ ус

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа үйлчилгээ худалгаа авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалт 47 дугаар зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2022 онд хэрэгжих Худгийн цооногийн ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах худалдан авах ажиллагааг зохион байгуулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга:

Э.Сувдмаа (ХХҮГ мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга: Л.Батбаатар (Багийн засаг дарга)

Гишүүн:

Д.Мөнхтуяа (Соёлын төвийн номын санч)

Гишүүн

Ц.Ундрахбаяр (3-р багийн Засаг дарга)

Гишүүн

Б.Алдармаа (Соёлын төвийн эрхлэгч)

2. Тендер шалгаруулалтыг хууль тогтоомжид заасан журмын дагуу зохион байгуулж, тендерийн үнэлгээний дүгнэлт шийдвэр гарган танилцуулахыг үнэлгээний хорооны дарга (Э.Сувдмаа)-д үүрэг болгосугай.

3. Тендерийн бичиг баримтыг хууль тогтоомжийн дагуу бүрдүүлж архивын нэгж үүсгэн архивт хүлээлгэн өгөхийг үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (Л.Батбаатар)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Ө.МӨНХ-АМГАЛАН